



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 4/57

Номгон

“Ундны усны чанар аюулгүй байдлыг  
шалгах, судалгаа хийх ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хүн амын ундны усны чанар, эрүүл аюулгүй байдлыг шалгаж, судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Хүрэлсүх (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Э.Сэмбэсүрэн (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Ням-Очир (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны мэргэжилтэн)

Э.Жамц (Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны мэргэжилтэн)

Ц.Урангоо-(Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Зүгдоржав (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ц.Баасанжав (Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь Тагнуулын хэлтсийн ажилтан, дэслэгч)

С.Цэдэнсодном (Чандмань-Баянхонгор ХХК-ий ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: Г.Нансалмаа-(Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн)


2.Ундны усны чанар, эрүүл аюулгүй байдлыг тогтоож, ажлын судалгааг 2022 оны 3 дугаар сарын 1-ний дотор хийж танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

601220127

2.

3.Дээрх ажилд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин уул уурхайн, нийгмийн салбар хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН